

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.10.29-11.02

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг түүхий эд боловсруулагч компаниудын хувьцааны ханш өссөн бол эрчим хүч, цахилгаан хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан байна. "Apple" компани цаашид ухаалаг гар утас, компьютер болон таблетын борлуулалтын тайлангаа нийтэд мэдээлэхгүй байхаар шийдвэрлэсэн нь тус компанийн хувьцааны ханш унах гол шалтгаан болжээ.

11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд Аргентин улсад болох "Их 20"-ийн чуулгын үеэр АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудалд ямар нэг дэвшил гарахгүй бол АНУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар БНХАУ-ын импортын бүх бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулна хэмээн мэдээлсэн. Үүний дараа хөрөнгийн зах зээлийн индексүүд унаж эхэлсэн билээ. Харин Пүрэв гарагт АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп БНХАУ-тай ашигтай шударга худалдааны гэрээг байгуулна хэмээн мэдэгдэж, зах зээлийн индексүүд өсч эхэлжээ.

Лхагва гарагт "Facebook" компанийн ашиг шинжээчдийн урьдчилсан таамагласан түвшнээс өндөр байж, тус компанийн хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. Энэ долоо хоногийн сүүлчээр "FactSet" агентлаг 3-р улиралд S&P 500 индексийн сагсанд багтдаг хувьцаат компаниудын ашиг 24.9%-аар өснө хэмээн үзжээ.

Европ: Энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Долоо хоногийн дунд үеэс худалдааны маргааны асуудал намжиж, Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсч эхлэв. Тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон Азийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

Германы Канцлер Ангела Меркель Консерватив намын даргын үүргээ хүлээлгэж өгөхөө мэдэгдсэн ч Европын хөрөнгийн зах зээл өсөлттэй байлаа.

Английн Төв банк бодлогын хүүгээ 0.75 хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргаснаар фунтийн ханш ам.долларын эсрэг чангарчээ. Хэдий тийм боловч BREXIT-ийн тодорхойгүй байдалтай холбоотойгоор бодлогын хүүг илүү богино хугацаанд өсгөж магадгүй байгааг шинжээчид онцолж байна.

3-р улиралд Европын эдийн засгийн өсөлт огцом удааширч, сүүлийн 5 жилийн доод түвшинд хүрлээ. Европын холбооны статистикийн газраас мэдээлснээр Европын бүсийн ДНБ өсөлт 1.8%-аас буурч 0.6%-тай тэнцжээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 4 долоо хоног дараалан нийт 10 орчим хувиар буурсны эцэст энэ долоо хоногт 5 хувийн өсөлт үзүүлээ.

Японы Төв банк богино хугацааны бодлогын хүүгээ -0.1%, 10 жилийн хугацаатай Засгийн газрын өгөөжийг 0.0%-д барихаар шийдвэрлэв. Мөн Төв банк 2020 онд суурь инфляцийг 1.5%-д хүрнэ хэмээн үзэж байна. Энэ нь зорилтот 2%-ийн түвшнээс бага хэвээр байгаа юм.

БНХАУ: АНУ нь БНХАУ-тай олон талт худалдааны гэрээ хийх талаар мэдээлэл гарч, БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд болон юанийн ханш өссөн байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,612.68	-0.19% ▼
Dow Jones	АНУ	25,270.83	2.36% ▲
S&P 500	АНУ	2,723.06	2.42% ▲
Nasdaq	АНУ	7,356.99	2.65% ▲
S&P/TSX	Канад	15,119.28	1.55% ▲
FTSE 100	Их Британи	7,094.12	2.23% ▲
S&P/ASX 200	Австрали	5,849.20	3.25% ▲
Nikkei 225	Япон	22,243.66	5.00% ▲
Hang Seng	Хонг Конг	26,486.35	7.16% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.79
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	95.51
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	94.83
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.25
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.52
DBM' 2023	USD	7.250%	98.06
TDBM' 2020	USD	9.375%	105.03

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.318	0.02 ▲
Libor 3M	2.592	0.07 ▲
Libor 6M	2.829	0.05 ▲
Libor 1YR	3.105	0.05 ▲
US 6M Bond	2.486	0.03 ▲
US 2YR Bond	2.895	0.09 ▲
US 3YR Bond	2.961	0.10 ▲
US 5YR Bond	3.023	0.11 ▲
US 10YR Bond	3.203	0.13 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.11.02	Өөрчлөлт
USD	2,565.74	0.07% ▲
CNY	372.02	0.70% ▲
EUR	2,934.18	0.58% ▲
RUB	39.13	0.13% ▲
KRW	2.29	1.78% ▲
JPY	22.71	-0.79% ▼
CAD	1,965.63	0.73% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,231.96	-0.24% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.71	-0.07% ▼
Зэс	USD/lb.	278.90	1.36% ▲
Нүүрс	USD/MT	102.85	-5.38% ▼
WTI газрын тос	USD/bbl.	62.67	-7.42% ▼
Brent газрын тос	USD/bbl.	72.41	-6.86% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.45	9.87% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. IX	5.70%
Бодлогын хүү	2018. IX	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. IX	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. IX	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	17.50%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. IX	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 40 компанийн 903.2 сая төгрөгийн 5,218,349 ширхэг хувьцаа арилжигдав.


“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 14.96%-аар буюу хамгийн ихээр өсч 22,740 төгрөгт хүрч хаагдсан бол “Ремикон” /RMC/ компанийн хувьцаа 29.41%-аар буурч 24 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 3,331 ширхэг үнэт цаас 343.3 сая төгрөгөөр арилжаалагджээ.

11-р сарын 02-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,411.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,612.68 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.19%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,246.5
Зах зээлийн үнэлгээ	2,411,756.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,612.68	-0.19% ▼
MSE I индекс	9,866.88	0.04% ▲
MSE II индекс	8,665.05	-3.17% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Айтүүлс	3,479,953	393,327,529
Ард даатгал	223,305	169,526,669
ЛэндМН ББСБ	1,122,509	84,261,358
АПУ	115,498	67,439,659
Говь	1,737	59,003,380

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	22,740.00	14.96% ▲
Дархан нэхий	21,200.00	11.17% ▲
Сүү	237.00	3.95% ▲
Махимпекс	2,700.00	3.85% ▲
Таван толгой	7,740.00	0.98% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ремикон	24.00	-29.41% ▼
Могойн гол	5,000.00	-20.95% ▼
Хай би ойл	42.00	-19.23% ▼
Мерекс	26.00	-18.70% ▼
Монгол нэхмэл	2,450.00	-14.04% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ эссет секьюритис Монгол	1,264,171,002
Стандарт инвестмент	857,176,014
Ард секьюритиз	288,374,376
Ти Ди Би Капитал	197,868,235
Голомт капитал	136,121,620

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	579.13	616,299
Таван толгой	7,740.00	407,629
Говь	34,200.00	266,798
МИК	11,000.00	227,803
Сүү	237.00	81,528

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-11/04/19-A0230-18	3,196	329,675,000	102,400	103,350	104	18.000%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	135	13,635,000	101,000	101,000	156	15.140%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Хай Би Ойл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 10-р сарын 29-ний өдрийн 9 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2018 оны 12-р сарын 10-ны 10:00 цагт

Хуралдах газар: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Баянгол зочид буудлын хурлын танхим

Бүртгэх өдөр: 2018 оны 11-р сарын 19-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд СХД, 20 дугаар хороо, Сонсголонгийн /18135/-110 компанийн байранд ирж танилцаж болно.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Мандал даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Мандал даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 18/007 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2018 оны 12-р сарын 12-ны 11:00 цагт

Хуралдах газар: Блю Скай зочид буудлын Кристал хурлын танхим

Бүртгэх өдөр: 2018 оны 11-р сарын 20-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, батлах;
2. Компанийн дүрмийг хэлэлцэж, батлах;
3. Компанийн хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбогдон гарсан зардлын тайланг танилцуулах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл 2018 оны 12-р сарын 1-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд СБД, 1-р хороо, Сөүл рестораны баруун талд Паркплэйс оффис төвийн 3 давхарт байрлах компанийн байранд ирж танилцаж болно.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Ч.Анар: Ирэх оны VI сард олон улсын том компанитай хамтран шинэ бүтээгдэхүүн гаргана

“ЛэндМН ББСБ” ХК-ийн толгой компани болох “Анд Системс” ХХК-ийн хаалттай хүрээнд гаргасан долоон тэрбум төгрөгийн бондыг БНСУ-ын “Rhinos Asset Management” компани худалдан авлаа.

Гурван жилийн хугацаатай, зургаан хувийн хүүтэй энэ бонд нь Монголын зах зээлд гарч байгаа анхны хувьцаа барьцаалсан бонд болсон байна. Ингэснээр дотоодын хөрөнгийн зах зээл дээр дахин нэг шинэ бүтээгдэхүүн гараад байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ: 2018 оны эхний 10 сард 82.7 тэрбум төгрөгийн хувьцаа арилжлаа

2018 оны эхний 10 сард Монголын Хөрөнгийн биржид 82.7 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаад байна. Хувьцааны арилжааны 63.2 хувь буюу 52.3 тэрбум төгрөгийг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа бүрдүүлжээ.

Хоёрдогч зах зээлийн арилжааны 21 хувийг, багцын арилжааны 26.6 хувийг “Говь”, “Тавантолгой”, “АПУ” компаниудын хувьцааны арилжаа бүрдүүлсэн байна. Мөн IPO гаргаад удаагүй байгаа компаниудын хоёрдогч зах зээлийн арилжаа 30 орчим хувийг бүрдүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 60 орчим хувийг зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч гурван компани, хөрөнгийн захад шинээр хөл тавьсан компаниудын хувьцааны арилжаа бүрдүүлсэн байна. Задлаад харвал, оны эхний 10 сард “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа хоёрдогч зах зээл дээр 7.3 тэрбум төгрөгөөр, “АПУ” компанийнх 6.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжигдсан байна. Мөн даатгалын хоёр компанийн хувьцаа арилжигдаад сар гаруйн хугацаанд нийт 2.7 тэрбум төгрөгийн арилжаа МХБ дээр хийгдээд байгаа юм. Компаниудын IPO амжилттай болж байгаагаас гадна, IPO гаргасан компаниудын хоёрдогч зах зээлийн арилжаа нь идэвхтэй байна гэж МХБ мэдээллээ. Он гарснаас хойш шинээр хөрөнгийн захад гараад байгаа компаниудын тоо эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор анхдагч зах зээлийн арилжааны дүн 30.4 тэрбум төгрөгт хүрч нийт хувьцааны арилжааны 36.8 хувийг бүрдүүлжээ.

2017 онд “Айтүүлс” ХК IPO гаргаж байхад эрэлт нь нийлүүлэлтээсээ гурав дахин давж, хувьцааны ханш нь 14 хоногийн дотор 2.5 дахин өсөж байсан. Мөн “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцааны захиалга нийлүүлэлтээ найм дахин давсан. Хамгийн сүүлд даатгалын компаниудын хувьцааг худалдан авах захиалга олон нийтэд санал болгосон дүнгээс давсан. IPO-оос IPO-ийн хооронд хөрөнгийн зах зээлд оролцогчдын мэдлэг дээшилж байгаагаас гадна шинэ бүтээгдэхүүний эрэлт зах зээлд байсаар байгааг “Голомт” болон “Худалдаа хөгжлийн банк”-ны кастодиан хэлтсийн захирлууд онцолсон. Мөн МХБ-ийн Гүйцэтгэх захирал ойрын хугацаанд шинээр гарахаар хүлээгдэж байгаа компаниуд нэмэгдэж байгааг мэдээлсэн юм. Харин Санхүүгийн зохицуулах хороо дан нийлүүлэлт талаас бус эрэлтийг зөв тодорхойлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад ч мөн анхаарч байгаагаа илэрхийлээд байна.

Хувьцааны ханшийн өөрчлөлтийг харвал, “ЛэндМН ББСБ”, “Мандал даатгал” болон “Ард даатгал” компаниудын хувьцааны ханш анх IPO гаргаснаас хойш өсөөд байна. Харин “Монгол Базальт”, “Эрдэнэ Ресурс Девелопмент” компаниудын хувьцааны ханш МХБ-д бүртгүүлснээс хойш буураад байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Монголбанкны орон нутаг дахь хэлтсүүд 33 кг алт худалдан авчээ

Дархан-Уул аймагт алтны сорьцын лаборатори шинээр нээгдсэний дараа буюу 10-р сарын 25-ны байдлаар Монголбанкны Дархан-Уул аймаг дахь хэлтэс 25.6 кг алт худалдаж авсан байна.

Харин Баянхонгор аймаг дахь Монголбанкны хэлтэс 7.4 кг алт худалдаж авсан гэж мэдээллээ. Монголбанк алт худалдан авалтаа нэмэгдүүлэх нь гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх нэг чиглэл гэж үзэж байгаа юм. Энэ хүрээнд орон нутагт дахин хоёр алтны сорьцын лаборатори нээх төлөвлөгөөтэй байгаа ажээ. 9-р сарын байдлаар Монголбанк нийт 14.3 тонн алт худалдаж аваад байна.

Монголбанк энэ онд 22 тонн алт худалдан авч гадаад валютын албан нөөцийн 760 сая ам.доллараар нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



WGC: III улиралд алтны эрэлт 964.3 тонн болж нэмэгдэв

Дэлхийн хэмжээнд алтны эрэлт III улиралд өмнөх оны мөн үеэс 6.2 тонноор нэмэгдэж, 964.3 тонн хүрснийг Дэлхийн алтны зөвлөл тайландаа тусгасан байна.

Тодруулбал, БНХАУ болон Энэтхэгт алтны эрэлт хамгийн их буюу 10 хувиар өсөж, цаашид Энэтхэгт 700-800 тонн, БНХАУ-д 900-1,000 тонн алтны эрэлт үүсэх төлөвтэй байгааг шинжээчид онцолж байна. Мөн энэ жил Төв банкнууд 400-500 тонн алт худалдан авах төлөвтэй байгаа ажээ. Алтны ханшийн хувьд 8-р сард 19 сарын доод түвшинд хүрч буурчээ. Хэдий тийм боловч цаашид унц алт 1,300 ам.доллар хүрч өснө гэж "Bloomberg"-ийн шинжээчид тооцоолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Xanadu Mines: "Хармагтай" ордын алт, зэсийн нөөц 249-400 хувиар өслөө

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Xanadu Mines" компани "Хармагтай" ордын нөөцийн төлөвийг шинэчлэн тогтоосноо зарлалаа.

Хайгуулын дүнд 2015 онд танилцуулсан нөөцийн дүнтэй харьцуулахад зэсийн агууламж 400 хувь, алтны агууламж 249 хувиар нэмэгдсэн гэж тус компани үзэж байна. Ингэснээр 1.9 сая тонн зэс, 4.3 сая унц алтны нөөцийг тогтоогоод байгаа аж. Дээрх тооцооллыг "CSA Global" компани жорк код болон "NI 43-101"-ийн дагуу бэлтгэн гаргажээ.

"Энэхүү өөрчлөлтийн дагуу бид удахгүй танилцуулах эдийн засгийн урьдчилсан судалгаагаараа "Хармагтай" орд бол санхүүгийн хувьд том боломж бүхий төсөл гэдгийг нотлон харуулна гэдэгт итгэлтэй байна" гэж "Xanadu Mines"-ийн Гүйцэтгэх захирал Андрою Стюарт мэдэгдлээ.

Үүнээс гадна тус компанийн санхүүгийн тайлан гарлаа. III улиралд тус компани Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгүүлсэн юм. Мөн 9-р сарын 30-ны байдлаар бэлэн мөнгөний тэнцэл нь 7.8 сая австрали доллар болоод байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Blackstone Resources: Монголд хайгуулын өрөмдлөг хийж эхлэв

Монголд өрөмдлөгийн төсөл хэрэгжүүлж эхэлсэн гэдгээ Швейцарын "Blackstone Resources" компани зарлалаа. Тус компани хайгуулын лиценз эзэмшдэг "Шар толгой", "Ар нуур", "Суванга" гэсэн ордуудад дээд тал нь 2,000 метр хүртэл гүнд өрөмдлөг хийх юм байна.

Түүхэн дата мэдээлэл, судалгаагаар эдгээр нь молибден, зэс, алтны нөөцтэй орд ажээ. Судалгаагаар молибдены 0.5 сая тонны нөөцтэй гэж гарсан байдаг байна. Өрөмдлөгийн ажил болон соронзон орны судалгаа хийснээр нэмж нөөц илрүүлэх боломжтой гэж "Blackstone Resources" компани үзэж байна.

"Blackstone Resources" нь Швейцарын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани бөгөөд зах зээлийн үнэлгээ нь 251.9 сая швейцар франк буюу 252.4 сая ам.доллар байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд хувьцааны үнэ нь 50 гаруй хувиар унажээ. Тус компани цахилгаан автомашины цэнэг хураагуурын үйлдвэрлэлд шаардлагатай кобальт, молибден, лити зэрэг металлын олборлолтоор дагнан бизнесээ эрхэлдэг. Цаашид цэнэг хураагуурын шинэ технологи бий болгохоор судалгааны төсөл эхлүүлээд байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Ургац хураалт өмнөх оноос 172.6 мянган тонноор илүү байна

Улсын хэмжээнд ургац хураалт дуусч урьдчилсан дүнгээр 409.6 мянган тонн үр тариа хураан аваад байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад 172.6 мянган тонн үр тариа илүү хураан аваад байна.

Ингэснээр манай улс улаан буудайн болон төмсний дотоодын хэрэгцээг 100 хувь хангах боломж бүрдсэн талаар Ургацын төв штабаас мэдээлж байна.

10-р сарын сүүлийн байдлаар 160.9 мянган тонн төмс, 93.6 мянган тонн хүнсний ногоо, 117.8 мянган тонн тэжээл, 19.3 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна. Өмнөх онтой харьцуулахад төмс 44.5 мянган тонноор, хүнсний ногоо 14.5 мянган тонноор, тэжээл 57.3 мянган тонноор, тосны ургамал 7.2 мянган тонноор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Хаврын тариалалт, намрын ургац хураалтыг хэвийн явуулахад нь тариаланчдад бүх талын дэмжлэг үзүүлснээр энэ жилийн тухайд урьд онуудаас тариалалт эрс нэмэгдэн, арвин ургац хураан аваад байна. Засгийн газраас 7 аймгийн 60 сумын 113 багийг газар тариалангийн бүс нутгаар тогтоон, хашаажуулах ажлыг эхлүүлэн, газар тариалангийн салбарт үр, сорт, техникийн шинэчлэл хийж, усалгаатай талбайг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж ирсэн юм гэдгийг ХХААХҮЯ-наас онцолж байна.

Эх сурвалж: Montsame.mn



БУСАД МЭДЭЭ

ОУВС Монгол Улсад 36.22 сая ам.долларын санхүүжилт олгохоор шийдвэрлэв

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн 5-р шатны үнэлгээг хэлэлцэж баталлаа.

5-р шатны үнэлгээгээр Монгол Улс 26.2088 сая зээлжих тусгай эрх буюу ойролцоогоор 36.22 сая ам.долларын санхүүжилт нэмж авах боломжтой болох юм. Энэ удаагийн санхүүжилтийг нэмж тооцооноор хөтөлбөрийн хүрээнд нийт 157.2454 сая зээлжих тусгай эрх буюу 217.33 сая ам.доллар болж байна.

ОУВС Монгол Улсыг дунд хугацааны бодлогыг эрчимжүүлэх, төсвийн бодлогоо чангатгах, гадаад валютын улсын нөөцөө нэмэгдүүлэхийн тулд бүх талаар анхаарах, мөнгөний бодлогоо чангатгах, банкуудыг дахин хөрөнгөжүүлэх ажлаа дуусгахыг зөвлөжээ. ОУВС-ийн дэмжлэгээр хэрэгжих Засгийн газрын “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” нь эдийн засгийг тогтворжуулах, төсвийн алдагдал, өрийн хэмжээг бууруулах, гадаад валютын нөөцийг нөхөн бүрдүүлэх, тэлэлт-агшилтын мөчлөгийн нөлөөллийг багасгах арга хэмжээг шинээр нэвтрүүлэх, хүртээмжтэй өсөлтийг дэмжих зорилготой юм.

Гурван жилийн хугацаатай хэрэгжүүлэх Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр нь өнгөрсөн оны 5-р сарын 24-нд батлагдсан бөгөөд энэ хүрээнд 314.5054 сая зээлжих тусгай эрх буюу ойролцоогоор 434.3 сая ам.долларын зээл олгороор шийдвэрлэсэн билээ.

Эх сурвалж: Montsame.mn

Дэлхийн Банк: Монгол Улс шинээр бизнес эхлэх, зээлийн хүртээмж, барилга худалдах зөвшөөрөл зэрэг үзүүлэлтээр урагшилсан

Дэлхийн банк бизнес эрхлэх орчныг дүгнэдэг “Doing Business” тайлангаа танилцууллаа. Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг “Doing Business” 2019 тайлангаар Монгол Улс бизнесийн орчны үзүүлэлтээрээ дэлхийн 190 орноос 74 дүгээр байрт жагссан байна. Энэ нь өмнөх оноос 12 байраар ухарсан ч 0.27 пунктээр дээшилсэн үзүүлэлт болжээ. Бизнес орчны илэрхийлэх 10 үзүүлэлтээс Монгол Улс шинээр бизнес эхлэх, зээлийн хүртээмж, барилга байгууламж худалдах зөвшөөрөл зэрэг үзүүлэлтээр өндөр оноо авсан байна. Харин дампуурлыг шийдэх, эрчим хүчинд холбогдох, гэрээ биелүүлэх зэрэг үзүүлэлтээр хамгийн бага оноо аваад байгаа юм. Монгол Улсын хувьд шинээр бизнес эхлүүлэх үзүүлэлт 0.01 пунктээр дээшилж, эрчим хүчинд холбогдох боломжийн үзүүлэлт 0.12 пунктээр буурсан. Мөн дампуурлыг шийдэх үзүүлэлт 0.09 пунктээр буурсан нь оноо буурахад голлон нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна. Харин жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалах, гэрээ биелүүлэх үзүүлэлтээр өнгөрсөн жилтэй харьцуулахад өндөр оноо авчээ. Монгол Улс зээлийн хүртээмжийн үзүүлэлтээр 190 орноос 22 дугаар байрт, барилга байгууламж худалдах зөвшөөрөл авах үзүүлэлтээр 23 дугаарт жагсаж байгаа нь хамгийн эерэг дүн болж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монголбанк: Гадаад валютын албан нөөц IX сард өмнөх сараас 1.4 хувиар өслөө

Гадаад валютын албан нөөц 9-р сард 2.89 тэрбум ам.долларт хүрч, 8-р сараас 1.4 хувиар өссөн байна. Хэдий тийм боловч он гарснаас хойш 3.8 хувиар буурсан талаар Төв банк мэдээлээ. 9-р сард төгрөгийн ханш 80 орчим төгрөгөөр унаж, Төв банк 157 сая ам.долларын интервенц хийсэн юм. 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөлд Төв банк гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, зээлийн хэмжээг бууруулах чиглэлээр ажиллах зорилтууд тусгаад байна. Энэ хүрээнд улсын гадаад валютын албан нөөцийг дунд хугацаанд одоогийнхоос хоёр дахин нэмэгдүүлж, зургаан тэрбум ам.долларт хүргэхээр зорьж байгаа юм. Энэ онд нийт албан нөөцийн гуравны нэг буюу 760 сая ам.долларыг алтны нөөцөөс бүрдүүлэхээр зорьж байна.

Валютын дотогшлох урсгалыг харвал 10-р сард олон улсын зах зээлд арилжаалсан 500 сая ам.долларын бондын санхүүжилт орж ирсэн гэж Хөгжлийн банк мэдээллээ. Мөн Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын зөвлөл 36 сая ам.долларын санхүүжилтийг батлаад байна.

Түүнчлэн Азийн хөгжлийн банкны санхүүжилт хүлээгдэж байгаа гэж Төв банк мэдээллээ. Ингэснээр он дуустал валютын нөөц нэмэгдэх боломжтой гэж Монголбанк дүгнэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

УИХ 2019 онд Төсвийн нийт алдагдлыг 1.9 их наяд төгрөг байхаар батлав

2019 оны Төсвийн тухай хуулийн төслийг УИХ баталлаа. Ингэхдээ нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг есөн их наяд 676 тэрбум төгрөг, нийт зардал 11 их наяд 589 тэрбум төгрөг байхаар баталлаа.

Өөрөөр хэлбэл, төсвийн нийт алдагдал нэг их наяд 912.6 тэрбум төгрөг буюу Засгийн газрын өргөн мэдүүлсэн түвшинд байна. Энэ нь алдагдлын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 5.4 хувьтай тэнцэх үзүүлэлт болж байгаа юм. Урт хугацаанд нь харвал төсвийн алдагдал сүүлийн дөрвөн жил дараалан хоёр их наяд орчим төгрөг байна. Хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгад дурдсанаар агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд төлөвлөсөн санхүүжилтийг 80 тэрбум төгрөгөөр, гаалийн шинэчлэлд зориулсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 2019 онд санхүүжих дүнг 12 тэрбум төгрөгөөр бууруулахаар болоод байгаа юм.

Мөн төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнг нэг их наяд 553 тэрбум төгрөгөөр батлав. Түүнчлэн Төсвийн тогтворжуулалтын санд 2019 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг 322 тэрбум төгрөгөөр баталлаа. Үүнээс гадна Засгийн газар 2019 оны төсвийн жилд шинээр хийх зээллэг болон өрийн баталгааны дээд хэмжээг хоёр их наяд 169 тэрбум төгрөг байхаар батлав.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.